



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2023/20/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2023 оны 3 дугаар сарын
24-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	2
Асуудлыг онцолсон хэсэг	2
Аудитын гол асуудал	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө	12
3.4.2 Авлага	13
3.4.3 Бараа материал	14
3.4.4 Үндсэн хөрөнгө	14
3.4.5 Өр төлбөр	15
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	15
3.4.7 Орлогын данс	16
3.4.8 Зардлын данс	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1. Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.7 Аудитын гол асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	23
5.1 ЗӨВЛӨМЖ	23
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.03.24 № 2/УО

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг сумын Засаг даргын Тамгын газар, Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 48,580.2 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" заалт болон Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын

талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баян-Өндөр сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 80.7 хувьтай тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,015,291.88	1,010,793.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	333,389.84	667,244.46
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	333,389.84	667,244.46
31210	Төгрөг	333,389.84	667,244.46
31211	Төрийн сангийн харилцах	333,389.84	667,244.46
33	АВЛАГА	314,663.84	298,496.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	86.85	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	161,420.00	0
33500	Бусад авлага	3,823.00	103,992.29
33510	Байгууллагаас авах авлага	3,823.00	103,748.05
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	244.25
33600	Зээлийн авлага	149,333.99	194,504.18
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	149,333.99	194,504.18
33612	Хувь хүмүүст олгосон зээл	149,333.99	194,504.18
35	БАРАА МАТЕРИАЛ	315,238.21	45,052.75
35100	Түүхий эд материал	15,397.61	1,581.80
35110	Тусгай зориулалттай материал	6,834.63	1,581.80
35130	Эм боох материал	8,562.98	0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	276.00	0
35400	Хангамжийн материал	299,564.60	43,470.95
35410	Бичиг хэргийн материал	5,568.97	1,038.00
35420	Аж ахуйн материал	17,960.29	273.00
35440	Түлш, шатах тослох материал	503.53	0
35450	Барилгын засварын материал	6,883.80	0
35460	Хүнсний материал	3,311.24	0
35470	Бусад хангамжийн материал	265,336.77	42,159.95
36	НӨӨЦИЙН БАРАА	52,000.00	0
36600	Бусад нөөц	52,000.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,075,667.72	1,876,731.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,075,667.72	1,876,731.22
39200	Биет хөрөнгө	4,002,073.11	1,833,743.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,234,786.89	2,961,435.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,813,602.67	-1,458,949.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	202,094.34	166,604.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-104,469.54	-102,145.21
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	621,176.64	247,632.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-366,647.71	-124,725.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	195,181.15	81,806.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-135,656.74	-56,556.45
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,067.20	0
39214	Бусад үндсэн хөрөнгө	158,726.33	139,126.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	-51,738.30	-44,994.71
39217	Ном	61,155.53	24,508.66
39300	Биет бус хөрөнгө	73,594.60	42,987.33
39301	Программ хангамж	2,835.00	1,075.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,052.40	-781.67
39303	Бусад биет бус хөрөнгө	72,812.00	42,694.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,090,959.60	2,887,524.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	141.40	76.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	141.40	76.06
41300	Өглөг	141.40	76.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	141.40	76.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,090,818.20	2,887,448.84
51	Засгийн газрын хувь оролцоо	5,090,818.20	2,887,448.84
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,046,905.09	697,852.98
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,046,905.09	697,852.98
51200	Хуримтлагдсан үр дүн	1,309,300.82	2,072,028.35
51210	Өмнөх үеийн үр дүн	1,009,505.02	4,110,209.26
51220	Тайлант үеийн үр дүн	299,795.80	-2,038,180.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,734,612.29	117,567.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,090,959.60	2,887,524.90

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,056,559.58	1,714,112.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	98,759.82	317,303.30
110	Орлогын албан татвар	89,293.62	188,100.63
1100	Хувь хүний орлогын албан татвар	89,293.62	188,100.63
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	116,253.13
110002	Үйл ажиллагааны орлого	26,874.19	22,936.80
110003	Хөрөнгийн орлого	59,409.43	46,726.70
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,010.00	2,184.00
113	Хөрөнгийн албан татвар	1,920.00	54,339.79
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	1,046.49
113002	Бууны албан татвар	1,920.00	2,336.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	50,957.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,546.20	74,862.89
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,327.58	7,116.20
118001	Улсын тэмдэгтийн хураамж	732.70	489.80
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,594.88	6,626.40
1181	Газрын төлбөр	1,218.63	1,819.69
118101	Газрын төлбөр	1,218.63	1,819.69
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	65,472.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	65,472.00
1183	Бусад татвар	0	455.00
118301	Бусад татвар	0	455.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	415,772.82	255,073.44
120	Нийтлэг татварын бус орлого	415,772.82	255,073.44
120003	Торгуулийн орлого	8,620.00	6,844.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,185.00	43,358.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,185.00	2,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	3,158.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	37,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	297,141.94	204,871.44
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	107,825.88	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,542,026.94	1,141,735.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,369,538.32	20,304.35
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,536.52	20,304.35
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,337,001.80	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	559,175.84	111,585.65
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,686.44	1,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,309.40	105,285.65
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	298,180.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,598,496.73	1,009,845.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	770,888.53	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	573,666.80	492,301.20
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	253,941.40	517,544.60
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,816.05	0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,816.05	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,756,708.46	1,152,434.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,756,708.46	1,152,434.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,642,799.01	874,133.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,737.78	262,560.06
210101	Үндсэн цалин	1,293,737.78	251,467.53
210102	Нэмэгдэл	0	8,894.59
210104	Урамшуулал	0	1,786.97
210105	Гэрээт ажлын хөлс	0	410.97

**Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,165.09	33,308.05
210201	Тэтгэврийн даатгал	118,531.31	22,929.12
210202	Тэтгэмжийн даатгал	13,210.16	2,697.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,474.05	2,124.38
210204	Ажилгүйдлийн даатгал	2,435.67	502.47
210205	Эрүүл мэндийн даатгал	24,513.91	5,054.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,175.55	49,638.15
210301	Гэрэл, цахилгаан	11,882.33	2,925.18
210302	Түлш, халаалт	191,723.22	46,712.96
210303	Цэвэр, бохир ус	570.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	141,052.04	91,510.87
210401	Бичиг хэрэг	6,755.18	5,364.36
210402	Тээвэр, шатахуун	54,527.59	39,338.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,164.04	3,925.60
210404	Ном, хэвлэл	623.80	427.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,585.85	3,344.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	61,842.36	511.30
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	37,500.00
210408	Бараа материал акталсны зардал	3,553.22	1,099.50
2105	Нормативт зардал	193,795.07	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	158,358.77	0
210502	Хоол, хүнс	34,486.31	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	950.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,283.67	5,801.65
210604	Урсгал засвар	37,283.67	5,801.65
2107	Томилолт, зочны зардал	6,042.70	6,367.60
210702	Дотоод албан томилолт	6,042.70	6,367.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,670.31	264,899.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239,832.34	262,450.49
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	701.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,525.90	1,129.00
210807	Газрын төлбөр	12.07	511.28
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	108.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,876.79	160,046.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,306.23	16,262.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,436.60	2,483.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	322,133.96	141,301.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,113,909.44	278,301.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,610.33	35,068.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,697.20	25,706.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,838.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,011.63	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,063.51	9,361.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	902,890.96	243,233.20
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	770,888.53	243,233.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,536.52	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	99,465.90	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,408.15	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,408.15	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	299,851.12	561,677.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	55.32	2,597,208.61
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	55.32	0
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	2,326,186.35
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	271,022.25
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	299,795.80	-2,035,530.91

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,668,640.92	1,513,920.91
11	ТАТВАРЫН ОРЛОГО	98,759.82	317,303.30
110	Орлогын албан татвар	89,293.62	188,100.63
1100	Хувь хүний орлогын албан татвар	89,293.62	188,100.63
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	116,253.13
110002	Үйл ажиллагааны орлого	26,874.19	22,936.80
110003	Хөрөнгийн орлого	59,409.43	46,726.70
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,010.00	2,184.00
113	Хөрөнгийн албан татвар	1,920.00	54,339.79
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	1,046.49
113002	Бууны албан татвар	1,920.00	2,336.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	50,957.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,546.20	74,862.89
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,327.58	7,116.20
118001	Улсын тэмдэгтийн хураамж	732.70	489.80
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,594.88	6,626.40
1181	Газрын төлбөр	1,218.63	1,819.69
118101	Газрын төлбөр	1,218.63	1,819.69
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	65,472.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	65,472.00
1183	Бусад татвар	0	455.00
118301	Бусад татвар	0	455.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,250.63	54,881.81
120	Нийтлэг татварын бус орлого	127,250.63	54,881.81
120003	Торгуулийн орлого	8,620.00	6,844.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,630.63	48,037.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,619.81	44,879.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,010.82	3,158.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,442,630.47	1,141,735.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,369,538.32	20,304.35
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,536.52	20,304.35
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,337,001.80	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	459,779.37	111,585.65
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,686.44	1,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,309.40	105,285.65
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	198,783.53	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,598,496.73	1,009,845.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	770,888.53	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	573,666.80	492,301.20
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	253,941.40	517,544.60
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,816.05	0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,816.05	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,301,699.18	910,457.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,301,699.18	910,457.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,182,997.73	750,262.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,834.71	299,646.83
210101	Үндсэн цалин	973,193.02	218,298.44
210102	Нэмэгдэл	192,317.33	9,292.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,524.00	0
210104	Урамшуулал	118,050.52	0
210105	Гэрээт ажлын хөлс	5,749.84	72,055.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,949.70	38,012.48
210201	Тэтгэврийн даатгал	122,374.92	26,124.75
210202	Тэтгэмжийн даатгал	11,878.52	3,091.58

**Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210203	ҮОМШӨ-ний даатгал	9,340.09	2,323.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,426.94	687.28
210205	Эрүүл мэндийн даатгал	22,929.24	5,785.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,589.35	223,529.12
210301	Гэрэл, цахилгаан	11,882.33	14,004.47
210302	Түлш, халаалт	191,137.02	206,673.05
210303	Цэвэр, бохир ус	570.00	2,851.60
2104	Хангамж, бараа материалын зардал	74,317.98	50,219.92
210401	Бичиг хэрэг	7,196.52	4,943.76
210402	Тээвэр, шатахуун	49,718.87	34,972.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,524.04	4,031.60
210404	Ном, хэвлэл	923.80	553.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,544.35	5,148.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,410.40	570.20
2105	Нормативт зардал	66,977.92	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,604.41	0
210502	Хоол, хүнс	36,640.81	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,732.70	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,214.87	7,986.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	564.00	0
210602	Тавилга	254.90	0
210604	Урсгал засвар	37,395.97	7,986.30
2107	Томилолт, зочны зардал	5,745.70	6,367.60
210702	Дотоод албан томилолт	5,745.70	6,367.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,480.85	5,226.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240,309.95	2,837.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	701.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,870.90	1,069.00
210807	Газрын төлбөр	0	511.28
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	108.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,886.66	119,272.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,127.46	116,629.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,759.20	2,643.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,118,701.44	160,195.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	129,579.33	36,143.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,697.20	25,706.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,838.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,011.63	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,032.51	10,436.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	906,713.96	124,052.39
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	770,888.53	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,536.52	20,304.35
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	103,288.90	103,748.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	82,408.15	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,408.15	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	366,941.74	603,462.96
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	281,408.33	269,608.34
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281,408.33	269,608.34
2200	Дотоод эх үүсвэрээр	281,408.33	269,608.34
220001	Барилга байгууламж	222,433.23	257,928.34
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,975.10	11,680.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-281,408.33	-269,608.34
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	85,533.42	333,854.62
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	247,856.42	333,389.84
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,389.84	667,244.46

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,046,905.09	1,761,032.33	983,084.98	4,791,022.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	26,420.04	26,420.04
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,046,905.09	1,761,032.33	1,009,505.02	4,817,442.44
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-26,420.04	0	-26,420.04
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	299,795.80	299,795.80
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,046,905.09	1,734,612.29	1,309,300.82	5,090,818.20
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,046,905.09	1,734,612.29	1,309,300.82	5,090,818.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,349,052.11	-1,616,738.45	2,800,908.44	-164,882.12
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	697,852.98	117,873.84	4,110,209.26	4,925,936.08
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-306.33	0	-306.33
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-2,035,530.91	-2,035,530.91
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	697,852.98	117,567.51	2,074,678.35	2,890,098.84

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,615,550.30	1,048,176.29	567,374.01	64.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,343.50	790,247.95	117,095.55	87.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,934.70	754,104.45	109,830.25	87.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,982.90	299,646.83	23,336.07	92.8
210101	Үндсэн цалин	224,742.00	218,298.44	6,443.56	97.1
210102	Нэмэгдэл	9,298.50	9,292.54	5.96	99.9
210105	Гэрээт ажлын хөлс	88,942.40	72,055.85	16,886.55	81.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,554.60	38,012.48	3,542.12	91.5
210201	Тэтгэврийн даатгал	28,370.90	26,124.75	2,246.15	92.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,777.00	3,091.58	-314.58	111.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,038.80	2,323.80	715.00	76.5
210204	Ажилгүйдлийн даатгал	905.90	687.28	218.62	75.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,462.00	5,785.07	676.93	89.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,174.60	223,529.12	8,645.48	96.3
210301	Гэрэл, цахилгаан	18,131.50	14,004.47	4,127.03	77.2
210302	Түлш, халаалт	210,043.10	206,673.05	3,370.05	98.4
210303	Цэвэр, бохир ус	4,000.00	2,851.60	1,148.40	71.3
2104	Хангамж, бараа материалын зардал	51,496.30	50,219.92	1,276.38	97.5
210401	Бичиг хэрэг	4,994.20	4,943.76	50.44	99.0
210402	Тээвэр, шатахуун	35,151.60	34,972.91	178.69	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,002.30	4,031.60	-29.30	100.7
210404	Ном, хэвлэл	550.00	553.45	-3.45	100.6

**Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,219.20	5,148.00	1,071.20	82.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	579.00	570.20	8.80	98.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,040.00	14,666.30	373.70	97.5
210602	Тавилга	7,040.00	6,680.00	360.00	94.9
210604	Урсгал засвар	8,000.00	7,986.30	13.70	99.8
2107	Томилолт, зочны зардал	6,452.00	6,367.60	84.40	98.7
210702	Дотоод албан томилолт	6,452.00	6,367.60	84.40	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,582.00	2,389.32	2,192.68	52.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.00	0.00	500.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	718.00	701.03	16.97	97.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40.00	0.00	40.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,224.00	1,069.00	1,155.00	48.1
210807	Газрын төлбөр	800.00	511.28	288.72	63.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	108.00	192.00	36.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,652.30	119,272.89	70,379.41	62.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	182,662.30	116,629.79	66,032.51	63.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,990.00	2,643.10	4,346.90	37.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,408.80	36,143.50	7,265.30	83.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,408.80	36,143.50	7,265.30	83.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,706.90	25,706.90	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,301.90	10,436.60	6,865.30	60.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	708,206.80	257,928.34	450,278.46	36.4
220001	Барилга байгууламж	708,206.80	257,928.34	450,278.46	36.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,615,550.30	1,313,477.66	302,072.64	81.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	520,406.80	0.00	520,406.80	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	823,481.20	1,265,439.85	-441,958.65	153.7
320001	Орон нутгийн төсвөөс	823,481.20	747,895.25	75,585.95	90.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	520,406.80	517,544.60	2,862.20	99.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	271,662.30	48,037.81	223,624.49	17.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,908.10	44,879.81	19,028.29	70.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	3,158.00	-2,158.00	315.8
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	206,754.20	0.00	206,754.20	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	265,501,318.41	-265,501,318.41	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	530,802,686.41	-530,802,686.41	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
610001	Төсвийн байгууллага	2	2	0	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	0	100.0
620001	Удирдах ажилтан	8	7	1	87.5
620002	Гүйцэтгэх ажилтан	12	14	-2	116.7
620003	Үйлчлэх ажилтан	3	1	2	33.3
620004	Гэрээт ажилтан	2	3	-1	150.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	8	1	88.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	0	100.0
650010	Гэрээт ажилтан	2	3	-1	150.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	0.00	100.0

Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,585.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,585.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,837.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,837.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,837.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,748.05
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	103,748.05
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	103,748.05
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,585.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,585.65
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,285.65

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Баян-Өндөр сум нь “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх” эрхэм зорилготой ажилласан байна.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах суурь зарчмуудыг баримтлан ажиллана. Үүнд:

- Хууль дээдлэх, шударга байх зарчим - Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа нь аливаа улс төр, үзэл суртлаас ангид байж, гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжийг дээдэлж, иргэдийн эрх ашигт нийцсэн байна.
- Иргэдэд үйлчлэх, шуурхай байх зарчим – Иргэдийн ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодит, цаг үеэ олсон, үнэн зөв мэдээлэл, бодлого чиглэлээр иргэдэд үйлчилж, шийдвэр гаргахад ашиглахад энэ зарчмыг баримтална.
- Ил тод, нээлттэй байх зарчим – Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа нь иргэдэд ил тод, нээлттэй байж, хэрэгцээт төрийн үйлчилгээг иргэн бүрд хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.
- Мэргэшсэн, тогтвортой байх зарчим – Сумын ЗДТГ нь цомхон, чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэн төлөвшүүлж, тогтвор суурьшилтай, төрийн албаны үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим болно.
- Хариуцлага хүлээх зарчим – Сумын ЗДТГ нь төрийн үйлчилгээг үзүүлэхдээ Монгол улсын иргэний өмнө хамтын болон ганцаарчилсан хариуцлагыг хүлээж ажиллана.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баян-Өндөр сумын төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТХС-ээс 2021 онд бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагууд, тусгай сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хууль хяналтын байгууллагаас хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,990,931.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 4,799,630.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	333,389.8	667,244.5	333,854.6
Авлага	314,663.8	301,146.5	(13,517.4)
Бараа материал	315,238.2	45,052.8	
Нөөцийн бараа	52,000.0	-	(52,000.0)
Үндсэн хөрөнгө	4,075,667.7	1,876,731.2	(2,198,936.5)
Нийт хөрөнгө	5,090,959.6	2,890,174.9	(2,200,784.7)
Өр төлбөр	141.4	76.1	(65.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,090,818.2	2,890,098.8	(2,200,719.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,090,959.6	2,890,174.9	(2,200,784.7)

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 333,389.8 мянга, эцсийн үлдэгдэл 667,244.5 мянган төгрөг болж 333,854.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	333,389.8	667,244.5	333,854.6	100%
Орон нутгийн ерөнхий орлого	67,888.5	136,441.8	68,553.3	20.4%
Орон нутгийн хөгжлийн сан	176,547.1	487,068.6	310,521.6	73.0%
Сум хөгжүүлэх сан	88,954.3	43,734.1	(45,220.2)	6.6%
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	333,389.8	667,244.5	333,854.6	100%

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 667,244.5 мянган төгрөгийн 43,734.1 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сан, 487,068.6 мянган төгрөг нь ОНХС-ийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын данс дахь 136,441.8 мянган төгрөгийн 56,491.2 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 79,950.5 мянган төгрөг нь орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

3.4.2 Авлага

Оны эхний 314,663.8 мянган төгрөгийн авлага 16,167.5 мянган төгрөгөөр буурч оны эцэст 298,496.5 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	86.9	-	(86.9)	0.0
Бусад авлага	3,823.0	103,992.3	100,169.3	34.8
Татаас санхүүжилтийн авлага	161,420.0	-	(161,420.0)	0.0
Зээлийн авлага /иргэн/	36,989.2	36,989.2	-	12.4
Зээлийн авлага /хоршоо/	112,344.8	157,515.0	45,170.2	52.8
Дүн	314,663.8	298,496.5	(16,167.4)	100.0

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тус сумын нийт авлагын 52.8 хувийг Сум хөгжүүлэх сан, 12.4 хувийг ОНХС-ийн малжуулах зээлийн авлага, 34.8 хувийг бусад авлага эзэлж байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Хувь хүмүүсээс авах авлага	Байгууллагаас авах авлага	Зээлийн авлага
1	ЗДТГ		103,315.8	244.2	103,071.6	
2	ИТХ		432.2		432.2	
3	ЕБС	3,823.0				
4	Цэцэрлэг					
5	ЭМТ	161,420.0				
6	Соёлын төв	86.9				
7	ОНХС	36,989.2	37,233.4		244.2	36,989.2
8	СХС	112,344.8	157,515.0			157,515.0
	ДҮН	314,663.8	298,496.5	244.2	103,748.0	194,504.2

Эх сурвалж: Баян-Өндөр сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн авлагын 34.5 хувийг сумын ЗДТГ-ын 103,071.6 мянган төгрөгийн авлага эзэлж байгаа ба өмнөх оны үлдэгдлийн 90,860.7 мянга, өвсний үнийн 6,710.3 мянга, усны

төлбөрийн 4,641.9 мянга, шүлхий өвчний шатахууны үлдэгдэл 972.0 мянга, цахим тендерийн хураамжийн 131.0 мянган төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлснийг авлагаар бүртгэсэн байна.

3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 367,238.2 мянга, эцсийн үлдэгдэл 45,052.8 мянган төгрөг болж, 321,909.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	6,834.6	1,581.8	(5,252.8)
Эм боох материал	8,563.0	-	(8,563.0)
Бэлэн бүтээгдэхүүн	276.0	-	(276.0)
Дуусаагүй үйлдвэрлэл			-
Бичиг хэргийн материал	5,569.0	1,038.0	(4,531.0)
Аж ахуйн материал	17,960.3	273.0	(17,687.3)
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал	503.5		(503.5)
Хүнсний материал	3,311.2	-	(3,311.2)
Барилгын засварын материал	6,883.8	-	(6,883.8)
Бусад хангамжийн материал	265,336.8	42,160.0	(223,176.8)
Нөөцийн бараа	52,000.0	-	(52,000.0)
Дүн	367,238.2	45,052.8	(322,185.5)

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 321,909.5 мянган төгрөг буюу 87.7 хувиар буурсан нь сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан оны эхний үлдэгдлийн 309,262.4 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассан нь бараа материал буурах голлох шалтгаан болжээ.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	41,275.5	41,815.3	539.8	32.3
2	ИТХ	2,940.5	3,237.5	297.0	2.5
3	ЕБС	100,057.3		(100,057.3)	0.0
4	Цэцэрлэг	62,212.2		(62,212.2)	0.0
5	ЭМТ	89,744.8		(89,744.8)	0.0
6	Соёлын төв	19,008.0		(19,008.0)	0.0
7	ОНХС	52,000.0		(52,000.0)	0.0
	ДҮН	367,238.2	45,052.8	(322,185.5)	34.8

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 60,610.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 37,500.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогоор бүртгэсэн, үйл ажиллагаанд нийт 97,273.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,549,835.1 мянга, эцсийн үлдэгдэл 3,664,883.4 мянган төгрөг болж, 2,884,951.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	5,234,786.9	2,961,435.5	(2,273,351.4)
Тээврийн хэрэгсэл	202,094.3	166,604.8	(35,489.5)
Машин тоног төхөөрөмж	621,176.6	247,632.9	(373,543.7)
Тавилга эд хогшил	195,181.2	81,806.0	(113,375.1)

**Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Номын фонд	61,155.5	24,508.7	(36,646.9)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,067.2	-	(1,067.2)
Бусад үндсэн хөрөнгө	158,726.3	139,126.5	(19,599.8)
Программ хангамж	2,835.0	1,075.0	(1,760.0)
Бусад биет бус хөрөнгө	72,812.0	42,694.0	(30,118.0)
Дүн	6,549,835.1	3,664,883.4	(2,884,951.7)

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сумын ЗДТГ нь 11,680.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 199,291.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн ба сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан 3,068,299.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	3,468,392.7	3,647,175.9	178,783.2	99.5%
2	ИТХ	13,142.5	17,707.5	4,565.0	0.5%
3	ЕБС	1,749,429.6		(1,749,429.6)	0.0%
4	Цэцэрлэг	443,266.8		(443,266.8)	0.0
5	ЭМТ	631,794.1		(631,794.1)	0.0
6	Соёлын төв	243,809.5		(243,809.5)	0.0
	ДҮН	6,549,835.1	3,664,883.4	(2,884,951.7)	100%

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 141.4 мянга, эцсийн үлдэгдэл 76.1 мянган төгрөг болж 45,604.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богоно хугацаат өр төлбөр дүн	141.4	76.1	(65.3)
Ажилчидтай холбогдсон өглөг	141.4	76.1	(65.3)
Байгууллагад төлөх өглөг			-
Хувь хүмүүст төлөх өглөг			-
Урт хугацаат өр төлбөр дүн			-
Дүн	141.4	76.1	(65.3)

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын ЗДТГ-аас бусад байгууллагууд Төсвийн тухай хуулийг мөрдөж, өглөггүй ажилласан ба сумын ЗДТГ оны эцэст ажиллагсадтай холбоотой 76.1 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,090,818.2 мянга, эцсийн үлдэгдэл 2,890,098.8 мянган төгрөг болж, 2,200,719.4 мянган төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,046,905.1	697,853.0	(1,349,052.1)	24.1
Хуримтлагдсан үр дүн	1,309,300.8	2,074,678.3	765,377.5	71.8
Өмнөх үеийн үр дүн	1,309,300.8	4,110,209.3	2,800,908.4	
Тайлант үеийн үр дүн		(2,035,530.9)	(2,035,530.9)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,734,612.3	117,567.5	(1,617,044.8)	4.1
Дүн	5,090,818.2	2,890,098.8	(2,200,719.4)	100

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 42,200,719.4 мянган төгрөгөөр буурсан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.13-ны өдрийн 06/30 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 256,000.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 8,000.0 мянган, нийт 264,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	256,000.0	317,303.3	61,303.3	123.9
Орлогын албан татвар	171,000.0	188,100.6	17,100.6	110.0
Хувь хүний орлогын албан татвар	105,000.0	139,189.9	34,189.9	132.6
Хадгаламжийн хүү	63,000.0	46,726.7	(16,273.3)	74.2
ҮХЭХ худалдсан борлуулсны албан татвар	3,000.0	2,184.0	(816.0)	72.8
Өмчийн татвар	73,500.0	54,339.8	(19,160.2)	73.9
ҮХЭХ-ийн татвар	1,200.0	1,046.5	(153.5)	87.2
Малын тоо толгойн албан татвар	70,000.0	50,957.3	(19,042.7)	72.8
Бууны албан татвар	2,300.0	2,336.0	36.0	101.6
Бусад татвар /төлбөр хураамж/	11,500.0	74,862.9	63,362.9	651.0
Тэмдэгтийн хураамж	1,500.0	489.8	(1,010.2)	32.7
Газрын төлбөр	3,500.0	1,819.7	(1,680.3)	52.0
Түгээмэл тархацтай ашиглалт малтмал ашигласны төлбөр	500.0		(500.0)	-
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	6,000.0	6,626.4	626.4	110.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	65,472.0	65,472.0	
Бусад татвар	-	455.0	455.0	
Татварын бус орлого	8,000.0	6,844.0	(1,156.0)	85.6
Торгуулийн орлого	8,000.0	6,844.0	(1,156.0)	85.6
ДҮН	264,000.0	324,147.3	60,147.3	122.8

Эх сурвалж: Татварын орлогын хэлбэлзэл, татварын байцаагчаас ирүүлсэн судалгаа

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 122.8 хувь буюу 60,147.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн, орлогын нэр төрлөөр авч үзвэл ноосны урамшуулал орж хувь хүний орлогын албан татвар 34,189.9 мянга, өмнөх оны өрийг барагдуулснаар хог хаягдлын үйлчилгээний төлбөр 626.4 мянган төгрөгөөр давсан, иргэн Мухмэдхасан Аливи 2 ширхэг шонхор шувуу барих гэрээ байгуулан, 65,472.0 мянган төгрөг орсон зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд оруулахаар төлөвлөсөн татварын дээрх 2 орлогоос бусад орлогын төлөвлөгөө тасарсан нь орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ аваагүйтэй холбоотой байна.

Баян-Өндөр сумын татварын байцаагч сумын татварын гүйцэтгэлийн мэдээг 325,592.0 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 1,902.8 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор сумын ЗДТГ 1,000.0 мянга, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 63,908.1 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 44,880.0 мянган төгрөг орсон нь ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага, идэвх санаачилга хангалтгүй байсантай холбоотой бөгөөд заалны

орлогоор ЗДТГ өөрийн орлогыг 2,158.0 мянган төгрөгөөр давуулж, 3,158.0 мянган төгрөгийг оруулжээ.

3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,615,550.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,048,176.3 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 566,718.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 223,529.1 мянган төгрөгийг тогтмол зардалд, 257,928.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.13-ны өдрийн 5/11 дүгээр тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,718,187.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.13-ны өдрийн 5/11 дүгээр тогтоолоор анх 1,718,187.8 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.09-ны өдрийн 08/50 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, урьд оны үлдэгдлийг 110,954.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг 31,967.9 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 81,623.8 мянган төгрөгөөр бууруулан анхны төсвөөс нийт дүнгээр 2,637.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,715,550.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Баян-Өндөр сумын 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

Санхүүжих эх үүсвэр	Дүн	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилт	520,406.8	30.3
Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	492,301.2	28.7
Сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого	264,000.0	15.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	273,934.2	16.0
Хандив, тусламжийн орлого	100,000.0	5.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	0.1
Сум хөгжүүлэх сангийн орлого	63,908.1	3.7
ДҮН	1,715,550.30	100.0

Эх сурвалж. Баян-Өндөр сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 08/50 дугаар тогтоол

Баян-Өндөр сумын ИТХ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийг үндэслэн хандив, тусламжийн орлогоор 100,000.0 мянган төгрөгийг оруулан, орон нутгийн санд зарцуулахаар төлөвлөсөн атлаа орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 13. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-т төвлөрүүлсэн
1	ЗДТГ	435,943.3	402,911.5	33,031.8	96.4	35,189.8
2	ИТХ	75,304.7	74,307.6	997.1	97.5	997.1
3	ЕБС	148,571.3	140,106.4	8,464.9	66.2	8,464.9
4	Цэцэрлэг	47,867.8	41,166.8	6,701.0	64.6	6,701.0
5	ЭМТ	24,494.4	23,189.6	1,304.8	94.7	1,304.8

6	Соёлын төв	22,299.7	18,466.0	3,833.7	91.4	3,833.7
7	ОНХС	708,206.8	257,928.3	450,278.5	34.8	
8	СХС	152,862.3	90,100.0	62,762.3	141.0	-
9	Орон нутгийн сан	100,000.0	-	100,000.0	0.0	
ДҮН		1,715,550.3	1,048,176.3	667,374.0	61.0	56,491.2

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,048,176.3 мянган төгрөг буюу 61.1 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 56,491.2 мянган төгрөгөөр хэмнэсэн, ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 450,278.5 мянган төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 62,762.3 мянга, хандив, тусламжийн орлогоор оруулахаар төлөвлөсөн 100,000.0 мянган төгрөг оруулаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 110,285.6 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 111,585.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 7,837.6 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 103,315.8 мянга, ИТХ 432.2 мянга, нийт 103,748.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Б.Идэрмөнх, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Г.Дүүрэнбилэг нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Их" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны баталсан төсөв 1,615,550.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,233.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,963.3 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.10-ны өдөр сумын Засаг даргаас 1/42 дугаар албан бичгээр ирүүлсэн, ирүүлсэн албан бичигт Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаж, дараах үр дүн гарсан гэж тайлагнасан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ орон тоо дутуу ажилласан тул цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, урамшууллын зардал хэмнэгдсэн;
- Халаалтын зардлыг халаалт аваагүй талбайд олгож байгаад хяналт тавьснаар зардлыг гүйцэтгэлээр олгож, хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,982.9	299,646.8	23,336.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,554.6	38,012.5	3,542.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,174.6	223,529.1	8,645.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,990.0	2,643.1	4,346.9
ДҮН	603,702.1	563,831.5	39,870.6

Эх сурвалж: Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баян-Өндөр сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 76 мэдээлэл оруулахаас 66 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Баян-Өндөр сумын харьяаны төсвийн 2 байгууллага, 2 сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл дутуу байршуулсан, орхигдуулсан зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өндөр сумын харьяаны төсвийн шууд захирагчийн тайланд төрийн аудитын байгууллагаас завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баян-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр аудит хийж, 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хариуг 2022.09.28-ны өдрийн 1/101 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд 36,989.2 мянган төгрөгийн малжуулах зээлийн авлага бүртгэлтэй, оны эцэст авлагын үлдэгдлийг малчдаар албажуулаагүй, нягтлан бодогчоос зээлийн үлдэгдлийг малчдаар гаргаагүй байхад сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нар хяналт тавьж ажиллаагүй байгаа тул ОНХС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгсөн тул хэрэгжүүлж, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, авлагыг баталгаажуулах шаардлагатай байна.

4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан ба ЭМТ, сургууль, цэцэрлэг, Соёлын байгууллагын орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 8,478.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

Хүснэгт 15. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
1	Баян-Өндөр сумын СХС	2022 онд хөнгөлөлттэй зээл олгосон 3 хоршооны төлөх хүүгийн авлагыг 8,100.0 мянган төгрөгөөр илүү, нэг иргэний зээлийн эргэн төлөлтийг 50.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	8,050.00	Материаллаг бус	Санхүүгийн аудит
2	Баян-Өндөр сумын ИТХ	Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 428.8 мянган төгрөгийн цалингийн өглөгөөр бүртгэсэн	428.8	Материаллаг бус	Санхүүгийн аудит
ДҮН			8,478.8		

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 232,055.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 18,880.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 29,700.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэн, 183,475.4 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт 16. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх	Зөрчлийн ангилал
A	1	2	3	4	5	6
1	Баян-Өндөр сумын ОНХС	Ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж, иргэнд харилцах данснаас санхүүжилтийг олгож, нягтлан бодох бүртгэлд өглөгөөр тусгасан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
2	Баян-Өндөр сумын ОНХС	Гүн өрмийн худаг гаргах ажлыг харьцуулалтын аргаар шалгаруулсан материалыг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд гэрээний дүнг 60,000.0 мянган төгрөгөөр мэдээлж, судалгаан дээр 44,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулснаар гаргасан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
3	Баян-Өндөр сумын ОНХС	Санхүүгийн тайланд бүртгэлтэй оны эхний авлагын 36,989.2 мянган төгрөгийн малчдаас авах авлагад тайлант онд өөрчлөлт ороогүй, авлагыг тайлант оны эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	36,989.2	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
4	Баян-Өндөр сумын ОНХС	Аудитад ирүүлсэн судалгааг үнэн зөв тайлагнаагүй, ажлыг хүлээн авсан актыг санхүүгийн баримтад бүрэн үдээгүй, малчдын авлагын судалгаа, бусад аудитад шаардлагатай баримт материалыг удаа дараа шаардуулсан, ирүүлээгүй.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Баян-Өндөр сумын ОНХС	Сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан 219,495.3 мянган төгрөгийн 20 худалдан авалтаас 200,295.3 мянган төгрөгийн 18 мэдээллийг Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг ирүүлсэн өдрөөс хойш мэдээлсэн, сумын Засаг даргын хөрөнгө зарцуулах 48,385.0 мянган төгрөгийн 6 захирамж, тайлант онд байгуулсан 246,278.3 мянган төгрөгийн 16 гэрээг байршуулаагүй орхигдуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
ДҮН			36,989.2			
1	Баян-Өндөр сумын СХС	Санхүүгийн тайлангийн зээлийн авлага, хоршоо хөгжүүлэх сангийн программ дахь 2022.12.31-ний өдрөөрх зээлийн үлдэгдлийг тулган шалгахад 8,080.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	8,080.0	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
2	Баян-Өндөр сумын СХС	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН 18,880.0 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй хугацаа хэтрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн байхад хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	18,880.0	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
3	Баян-Өндөр сумын СХС	Тайлант онд сумын Засаг даргын захирамжаар 3 хоршоонд 90,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай, 3 хувийн хүүтэй олгох шийдвэр гарч, зээл олгосон байхад таван сая төгрөгөөс дээших зарлагын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	90,000.0	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			116,960.0			
1	Баян-Өндөр сумын ЗДТГ	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 29700180 төгрөгийн "100мв дизель мотор" бодитоор байхгүй дутагдсан зөрчлийг тооллогын бүртгэлт тусгаагүй байгаагаар тоолж баталгаажуулсан.	29,700.2	Албан шаардлага	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын дагуу Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан санхүүгийн үр дагавар үүсгэх 48,406,235 төгрөгийн 2 гэрээг шилэн дансанд байршуулаагүй.	48,406.2	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			78,106.4			
0	НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН		232,055.6			

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 19,042.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 19,042.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн.

5.1. АЛБАН ШААРДЛАГА

1. Баян-Өндөр сум 2022 онд малын тоо толгойн албан татвараар 70,000.0 мянган төгрөг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 50,957.3 мянган төгрөгийн татварыг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 19,042.7 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд сумын малын тоо толгойн албан татварыг үнэн зөв тодорхойлон төлөвлөж, 2022 оны дутуу татвар, 2023 оны татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлага өгөв.

5.2. ЗӨВЛӨМЖ

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 240,534.4 мянган төгрөгийн 2 алдаа, 10 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг тооцож ажиллах

2. Илрүүлэлт: Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" заалтын дагуу аймаг, сумын Засаг дарга аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээг сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгж байгууллагатай сум, орон нутгийн удирдлагуудтай байгуулсан гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулж байх

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 240,534.4 мянган төгрөгийн 2 алдаа, 10 зөрчил илэрсэн байна.	1	-							1	-			
Дүн	1	-	0	-	0	-	1	-	0		0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Малын тоо толгойн албан татвараар 70,000.0 мянган төгрөг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 50,957.3 мянган төгрөгийн татварыг оруулж, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.	1	19,042.7			1	19,042.7		
Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" заалтын дагуу аймгийн Засаг дарга, "Эрдэнэ монгол" ХК-тай байгуулсан гэрээг сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	0					1	0
Дүн	2	0	0	-	1	19042.7	1	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 167/А0570238/ВНА-
2023/20/НА - СТА ЭЦУЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Өндөр сум 2022 онд малын тоо толгойн албан татвараар 70,000,000 төгрөг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 50,957,300 төгрөгийн албан татварыг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 19,042,700 төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан, зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" зэргийг үндэслэн

ШААРДАХ нь:

D/2023-ASH

005040392

1. Сумын төсөвт төвлөрүүлэх малын тоо толгойн албан татварыг үнэн зөв тодорхойлон төлөвлөж, 2022 оны төлөгдөөгүй дутуу татвар, 2023 оны төлөвлөсөн татварыг хуулийн хугацаанд нь орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлэх
2. Аудитаар өгсөн 19,042,700 (Арван есөн сая дөчин хоёр мянга долоон зуун) төгрөгийн албан шаардлагын биелэлтийг, холбогдох нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Идэрмөнх, санхүүгийн албаны дарга Г.Дүүрэнбилэг, татварын байцаагч Ү.Зандраасүрэн нарт хариуцуулав².


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэгээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгаан шийтгэл ногдуулах үндэслэл болно.

³ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."